# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛЬД ОРОЛЦОХ МОНГОЛЫН ХӨРӨНГӨТНИЙ НАМЫН ХӨТӨЛБӨР

1996 оны 04 дүгээр сарын 19-ны өдөр

Улаанбаатар хот

Монголын хөрөнгөтний намын улс төрийн зөвлөлөөс 1996 оны Улсын Их Хурлын сонгуульд "ТАНЫ ХҮСЭЛ,ТА БИДНИЙ ЗҮТГЭЛ,ТАЛЫН МОНГОЛЫН ХӨГЖИЛ" уриан дор оролцох шийдвэр гаргаж байна. Энэ удаагийн сонгуулийн хугацаа нь Монгол улсын хөгжлийн хувь заяаг шийдвэрлэх ує бөгөөд сонгуулийн мөрийн хөтөлбөр нь засгийн эрх авахын тулд гаргадаг хоосон амлалт байх ёсгүй гэж үзэж байна.

Манай нам улс төр,албан тушаалын хийрхэлээс ангид байж хөдөлмөрийн ард түмэнтэйгээ нэг агаараар амьсгалан хийж бүтээх, сурч мэдэхийг эрхэм болгосоор тодорхой амжилтанд хүрч,олон түмнийхээ итгэлийг хүлээсний хувьд,эдийн засаг-нийгмийн тулгамдсан асуудалд оновчтой дүгнэлт хийн шийдвэр гаргахдаа өчигдөрийн социализм,маргаашийн капитализм,өнөөдрийн өрөвдүүлэх байр сууринаас бус,амьдралын бодит шаардлагатай уялдуулан үзэл баримтлалаа мөрдлөг болгож байна.

Ард түмнийхээ амьдралыг дээшлүүлэхийн төлөө Үндэсний хөрөнгөтөн,эрдэм оюуны чадавхийг төвлөрүүлэн зохион байгуулж,олон түмний дэмжлэгт түшиглэн хөдөлвөөс мэдэхгүй,чадахгүй зүйл үгүй болохыг дан ганц бидний сэтгэлийн чин зориг мэднэ.Бид чухамхуу олсон амжилт,хийсэн бүтээл,хуримтлуулсан туршлагаараа олон түмнийхээ итгэл найдварыг бий болгон төр,засгийн нэр хүндийг өргөж чадна.Нэр хүндгүй,төр засаг улс орныг хэзээ ч жолоодож чадахгүй.

Улс орны хөгжилд ур өгөөжөө өгөөгүй цагт хязгааргүй тал нутаг түүний баялгийн талаар сэтгэлээ цатган,эзэн Чингисийн сүнсийг дуудаад ч нэмэргүй.

Монголчуудад хангалттай баялаг байна.Тэр нь хүн ба түүний хөдөлмөр,цаг хугацаа бусдын түүхэн туршлага юм.

Ард түмний амьдралын хүнд асуудлыг хөндсөн том амлалт хийснээр засгийн эрхэнд гарах гэсэн улс төрийн намууд нэлээн гарах нь олон улсын түүхэнд ийм асуудал нэг бус удаа гарч байсныг бид бүгд мэднэ.Сонгуулиар бодлогоо хэрэгжүүлэх эрх авсан нам,хувь хүн болон аливаа тогтолцоог чөлөөтэй хөгжих нөхцөлийг бүрдүүлэн,улс орны эдийн засгийн асуудалд ямар ахиц гаргав гэдгээр үнэлэгдэх ёстой.Монголын эдийн засгийн хямрал,сүйрлийн тухай их яригдаж байна.Байгаль эхэд залбиран байж олдог хэдэн малын ашиг,шимийг эс тооцвол "Монголын" эдийн засаг гэдэг асуудал нь өөрөө юу байх вэ.

Хөгжсөн орны загвараар өмч хувьчлалыг явуулсан,хуучин дарга шинэ хөрөнгөтөнд хувирч байгаа болон хувийн хэвшлийг туушгай дэмжээгүйгээс өөнөө хир тоогий нь ч тогтоож чадаагүй байгаа асар их валютын зээлээр бий болсон жоохон хөрөнгө нь нурсан балгас,хаягдал төмөр болж хувирав.

Харин ардчилал,эах зээлийн асуудал тавигдсанаас хойш иргэдийн хөрөнгжилт,нүд тайлж бий болсон хүсэл хоёрыг хөдөлмөрт чиглүүлж чадвал монголын эдийн засгийн суурийг тавих бодит алхам сая хийгдэнэ.Хэдий богино хугацаа өнгөрсөн боловч хувийн хэвшлийн хувь нэмэр чамлалтгүй.Ямарч л байсан ард түмнийхээ хувцас,хоолыг нь залгуулсаар байна.

Манай нам дан ганц байгалийн хишгийг харах бус сэтгэлгээт хүний шударга хөдөлмөрөөр бий болох баялгийг бүх талаар дэмжих бодлого явуулна.

Цаг хугацаа хөдөлмөрөөрөө шалгаран гарсан хувийн аж ахуйн нэгж хөрөнгөтнүүдийг улсын чанартай томоохон төслүүдэд оролцох боломж олгох ба хувийн хэвшлийнхнийг одоогийн мухардлаас гаргах бодлого явуулж бүх талын дэмжлэг хийх шаардлагатай гэж үзэж байна.Ингэж чадвал монгол улсын эдийн засгийн талаар зоригтой ярьж болох байна.

Манай намын бодлого,үйл ажиллагаа үндэсний хөрөнгө чинээлэг хүмүүс,хөрөнгө хуримтлал,материаллаг баялгийг бий болгоход түлхүү чиглэгддэг ч аливаа улс төрийн нам,бас монголын ард түмний хувь заяа,өмч хөрөнгөөр тоглохыг хэрхэвч зөвшөөрөхгүй. Ийм ч учраас төрийн эрх барих байгууллагад өөрийн төлөөллийг бий болгох зорилт тавьж сонгогчдынхоо олгосон боломжоор идэвхитэй ажиллах болно.

Нийгэмд хуримтлагдаж буй оюуны болон бусад баялгийг арвижуулах бүхий л боломжийг ханган,өөрөө өөрсдийнхөө хөгжил дэвшлийг боймолсон элдэв тогтолцоо,ёс суртахуун,хууль шийдвэрийг богино хугацаанд өөрчлөх шаардлагатай бөгөөд цаг алгуурлан бүх түвшиний хариуцлагыг цалгардуулбал түүх биднийг өршөөхгүй.

"Ардчилал" гэдгийг нэн түрүүнд хариуцлага ба түүнийг ухамсарласан үйлдэл гэж үзэн,нийгмийн элдвэв сөрөг үзэгдэл,замбараагүй байдлыг таслан зогсооно.

"Зах зээл" нь байгалийн шалгарлын хүрээн дэх хүн нийгмийн шалгарлын тогтолцоо хэмээн үзэж,сэтгэж,бүтээн байгуулан,шударга хөдөлмөрлөж байгаа хүн бүрийг улс төрийн харьяалал,үзэл бодол, яс үндэс,хүйс,шашин шүтлэг нийгмийн гарал,үүсэл,төрсөн орон нутгийг үл харгалзан дэмжинэ.

Бид мөнгө амлахгүй.Харин ажлын байраар хангаж,чөлөөт сэтгэн бодох,бүтээн туурвах,хөдөлмөрийн амт шимтээ мэдрэх боломж олгоно.

Бид хуулийн амнө тэгш эрхтэй байх зарчмыг баримтлана.

Хөрөнгөтний нам өнгөрсөн,одоо,ирээдүйн харилцан шүтэлцээг аливаа улс төрийн бодлого,үйл ажиллагаандаа тулгуурлан өнгөрсөн үеийнхээ хийж бүтээснийг хүндэтгэн хөгжүүлнэ.Хөгжсөн орнуудын түүхэн замнал,өнөөгийн хөгжлийн алдаа оноонoос сургамж авч харьцангуй богино хугацаанд бага алдаж амжилтанд хүрэх боломжийг үгүйсгэхгүй.Өндөр хөгжсөн орнуудад тулгарч буй нийгэм эдийн засаг,сэтгэлгээ,шашин шүтлэг,экологи,гинетикийн зэрэг асуудлуудтай уялдан тавигдаж буй хөгжлийн ойрын ба хэтийн зорилтыг байнга анхаарлын төвд байлгах шаардлага ч гарч байна.

Гадаад бодлогодоо үндэсний эрх ашиг,аюулгүй байдал,хөгжил цэцэглэлтийг эрхэмлэнэ.Аливаа улс орон үндэстэн,ястан,шашин шүтлэгийн бие даасан байдлыг хүндэтгэн эрх ашиг тэгш харилцана.

Олон улсын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.Энхтайван ч бодлого явуулж аливаа зөрчлийг улс төрийн аргаар шийдвэрлэнэ. Гадаад хөрөнгө оруулалтыг бүхий л талаар дэмжин хамгаалах нь олон улсын улс төрийн байгууллагын анхаарлыг өөртөө татах бөгөөд энэ алхам нь манай улсын аюулгүй байдлын чухал баталгаа болно гэж үзнэ.

Манай намын олон жилийн практик үйл ажиллагаа,судалгааны үр дүнд макро,микро эдийн засгийн хөгжлийн асуудал,улсын төсөв санхүүгийн бүрдэл,хүчин чадлыг дээшлүүлэх,гадны хөрөнгө оруулалтыг эрс нэмэгдүүлэх олон улсын болон бүс нутгийн төсөл хэрэгжилтийг татах,нийгэм халамжийн талаар төрөлжсөн хөтөлбөрүүд боловсруулсан болно.Үүнд боловсрол,шинжлэх ухаан,

соел урлаг,эрүүл мэнд,спорт,төр,хууль,төсвийн албан хаагчдын талаар явуулах тодорхой арга хэмжээнүүд тусгагдсан болно.

Дээрхи асуудлуудыг улс төрийн бие даасан бодлогын түвшинд боловсруулж,богино хугацаанд үр дүнд хүрэх боломжийг тусгаж, олсон амжилт,алхам бүрээ суурь болгон "би өөрөө,бид өөрсдөө хувь заяанхаа эзэн" гэсэн зарчмаар асуудалд хандаж байна.

Манай намд итгэл хүлээлгэн бодлогоо хэрэгжүүлэх боломж олговол төрөлжсөн хөтөлбөрүүдийг ард түмний төлөөлөгч болох их хурлын гишүүдээр хэлэлцүүлэн хэрэгжүүлэлтэд эрдэм чадвартай хүмүүсийг улс төрийн харьяалал болон бусад ялгаварлыг үл харгалзан татан оролцуулах болно.

Бид ард түмний цэрэг.

Та биднийг дэмжвэл

Бид ямарч нөхцөлд "Монгол улсын төлөө зүтгэе".

МОНГОЛЫН ХӨРӨНГӨТНИЙ НАМ